



ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Их хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Сангийн сайдын дангаар болон бусад сайдтай хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний 2024 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлгээ өгсөн тайланг танилцуулж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу "Алсын хараа 2050"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт 28 арга хэмжээнээс хамааралгүй 10 арга хэмжээг хасаж тооцвол 18 арга хэмжээнээс 16 арга хэмжээ 100.0 хувийн, 1 арга хэмжээ 90.0 хувийн хэрэгжилттэй, 1 арга хэмжээ 50.0 хувийн хэрэгжилттэй ерөнхий дүнгээр 96.7 хувьтай байна. Мөн "Алсын хараа-2050"-ыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 3 шалгуур үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд ерөнхий дүнгээр 100 хувийн хэрэгжилттэй байна.

“Алсын хараа-2050” хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

(2024 оны жилийн эцсийн байдлаар)

№	Бодлого	Арга хэмжээ	Хувь				
			100	90	50	Хамааралгүй	Үнэлгээ
1	АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА	4	2			2	100.0
2	ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	21	12	1	1	7	95.7
3	ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО	2	1			1	100.0
4	БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО	1	1				100.0
Нийт		28	16	1	1	10	96.7

“Алсын хараа 2050”
Сангийн яам
2024 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээ
Гурав. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА							
1	3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	3.3.19. Зээлийн батлан даалтын санг сурталчлах, үйл ажиллагааг нь өргөжүүлж сайжруулна.	2020 - 2050			Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Коронавируст /Ковид-19/ цар тахлын сөрөг нөлөөг бууруулах зорилгоор батлагдсан Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн төлөвлөгөө батлах тухай 42 дугаар тогтоолоор Зээлийн батлан даалтын сангийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, тус сангаас нэмж 1 их наяд төгрөгийн зээлийн батлан даалт гаргах санхүүгийн чадавхыг бүрдүүлсэн. Ингэснээр дээрх тогтоолын хүрээнд арилжааны банкнуудаар дамжуулан олгосон Ажлын байрыг дэмжих зээл, Репо санхүүжилтийн зээлд хамрагдах санхүүгийн хэрэгцээ шаардлагатай боловч барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжүүдэд тус сангаас үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн. Түүнчлэн, Зээлийн батлан даалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газраас санаачлан боловсруулж, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн бөгөөд 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар тус хуульд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг баталж, уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр төрөөс хэрэгжүүлж буй төвлөрлийг сааруулах, иргэдийг орон сууцжуулах бодлогын хүрээнд урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн тус сангаар дамжуулан зээлийн батлан даалтын үйлчилгээ авах эрх зүйн боломж бүрдсэн. Тухайлбал, орон сууцны урьдчилгаа төлбөрийн дутагдалтай иргэн тус санд хандаж зээлийн батлан даалтын үйлчилгээ авснаар банкнаас тогтоосон 30 хувийн урьдчилгаа төлбөрийн 60 хүртэлх хувийг буюу нийт урьдчилгаа	Хамааралгүй

					төлбөрийн 18 хүртэлх хувьд тус сангаар батлан даалт гаргуулж, үлдсэн 12 хувийг өөрөө бүрдүүлэх замаар орон сууцны зээлд хамрагдах боломж бүрдсэн. ЗБДС-ийн удирдлага, үйл ажиллагааны бодлого, зохицуулалтын асуудал холбогдох хууль тогтоомжийн дагуу ХХААХҮЯ-д шилжсэн тул цаашид энэ арга хэмжээний хэрэгжилтийг ХХААХҮЯ-аас гаргуулах, Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах саналтай байна.	
2		3.3.23. Экспорт, импортын зах зээлтэй холбоотой мэдээллийг цахимжуулж, экспортын зах зээлд нэвтрэх боломжийг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.	2020 - 2050		Засгийн газраас уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тогтолцоог нэтрүүлж, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг нээлттэй, ил тод зах зээлийн үнээр борлуулах боломжийг бүрдүүлсэн. Биржийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор биржээр арилжаалсан ашигт малтмалын бүтээгдэхүүний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ногдуулах борлуулалтын үнэлгээг биржийн үнэд үндэслэн тооцох зохицуулалтыг тусгаж, Засгийн газрын 2023 оны 345, 2024 оны 73 дугаар тогтоолыг тус тус баталсан. “Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг үндэслэн гадаад худалдааны 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2024 оны сар бүрийн барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж, гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics сайтад тогтмол байршуулсан. “Барааны экспорт, импортыг бүртгэх, статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг үндэслэн гадаад худалдааны 2023 оны урьдчилсан болон жилийн эцсийн гүйцэтгэл, 2024 оны 1-11 дүгээр саруудын барааны статистик мэдээлэл, динамик статистик мэдээллийг боловсруулж, гаалийн цахим хуудас www.gaali.mn/statistics сайтад тогтмол байршуулсан. Мөн Үндэсний Статистикийн Хороо, Гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны 14/2017-01 дугаар “Мэдээлэл солилцох асуудлаар хамтран ажиллах гэрээ”-ний дагуу барааны экспорт, импортын статистикийн 2023 оны жилийн эцсийн, 2024 оны 1-11 дүгээр саруудын мэдээллийг цахим хэлбэрээр амжилттай илгээсэн. Үндэсний Статистикийн хорооноос Гаалийн ерөнхий газрыг "ШИЛДЭГ МЭДЭЭЛЭГЧ" байгууллагаар шалгаруулсан.	100%

3	3.4. Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээ үзүүлж эрсдэлээс хамгаална.	3.4.1. Бага, дунд орлоготой иргэдэд эзлтэй банк санхүүгийн үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	2020 - 2050			Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.2-т заасан "Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд төсөв, санхүүгийн бодлогоор дэмжлэг үзүүлэх" арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутагт шилжин суурьшигчдыг дэмжих хүрээнд арилжааны 6 банкаар дамжуулан нийт 3,839 зээлдэгчдэд 379.7 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар олгожээ. Эдгээр хөнгөлөлтэй зээлд хамрагдсан зээлдэгчдээс 816 зээлдэгчдийн 17.8 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийг Зээлийн батлан даалтын сангийн батлан даалтад хамруулсан дүнтэй байна.	100%
4		3.4.2. Бичил, жижиг, дунд бизнесийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүн ийг нэмэгдүүлэх, төрөлжүүлэх замаар эрэлтэд нийцсэн зээлийн бүтээгдэхүүн (итгэлийн зээл, лизинг санхүүгийн шинэ төрлийн олон хэлбэрийн үйлчилгээ) бий болгоно.	2020 - 2050			Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” 166 дугаар тогтоолын хавсралтаар "Шинэ хоршоо-чинээлэг малчин" арга хэмжээний төлөвлөгөөг баталсан. “Шинэ хоршоо-Чинээлэг малчин” арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан хоршооны гишүүн малчинд хөрөнгө оруулалтын зориулалтаар олгох хөнгөлөлттэй зээлийн хүүгийн дэмжлэгт зориулан 143.4 тэрбум төгрөгийг “Монгол Улсын 2025 оны төсвийн тухай” хуулийн төсөлд ХХААХҮСайдын багцад тусгасан байна. Цаашид энэ арга хэмжээний хэрэгжилтийг ХХААХҮЯ-аас гаргуулах нь зүйтэй.	Хамааралгүй

Дөрөв. ЭДИЙН ЗАСАГ

5	4.1. Макро эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох бүлэг болгоно.	4.1.1. Гадаадын зээлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдэд зардал, үр ашгийн тооцоолол хийж, зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэх тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлнэ.	2020 - 2050		Гадаад зээлээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, төсөвт өртгийг тооцох, үнэлэх, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлдэг бөгөөд Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмыг баримтлан төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна.Түүнчлэн, Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилтод "Эдийн засгийн бодит өсөлт болон экспортын орлогыг нэмэгдүүлэхгүй, гадаад улс орны худалдан авалтыг дэмжих замаар импортыг өсгөж, төлбөрийн тэнцэлд дарамт учруулах нөлөө бүхий Засгийн газрын гадаад зээлийн эх үүсвэрийг авч ашиглахаас татгалзах;" болон "Өрийн удирдлагын тухай хуулийн 7.1.6-д[10] зааснаас бусад тохиолдолд зөвхөн бодит эдийн засгийн салбарт чиглэсэн төслийг санхүүжүүлэх зориулалтаар Засгийн газрын гадаад зээл авч ашиглах;" гэж тусгасан. Энэ хүрээнд 2024 онд засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нийт 7 төслийг зээлийн гэрээг байгуулсан.	100%
6		4.1.2. “Ирээдүйн өв сан”-д орлого төвлөрүүлэх, баялгийн сангийн хөрөнгийг оновчтой удирдан, эрсдэл даах	2020 - 2050		Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан байгалийн баялаг, түүний дотор газрын хэвлийн баялгийг ашиглах суурь зарчим, нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас бий болсон үр өгөөжийг өнөө ба хойч үеийн иргэн бүрд тэнцвэртэй хуваарилах үзэл санааг хэрэгжүүлэх зорилготой Үндэсний баялгийн сангийн тухай хууль 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр батлагдан, хүчин төгөлдөр хэрэгжиж эхлээд байна. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 9 дугаар зүйлийн 9.1-д баялгийн сан нь Ирээдүйн өв сан, Хуримтлалын сан, Хөгжлийн сан гэж төрөлжсөн сантай байхаар заасан. Уг хуулиар Ирээдүйн	90%

		эдийн засгийг бүрдүүлнэ.			өв сангийн эх үүсвэр нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтворжуулалтын болон Орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь байх ба 2024 онд 20 хувь байхаар тус тус зохицуулсан бөгөөд 2030 он хүртэл зарцуулалт хийхгүй. Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 1,824,581,388,613.62 төгрөг, 628,590,673.64 ам.доллар, нийт үлдэгдэл 3,971,262,540,441.37 төгрөгтэй тэнцэж байна. Хуримтлалын сангийн эх үүсвэр нь уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд дэх төрийн эзэмших хувьцаа 34 хувь хүртэлх бол түүний төрийн эзэмшилд ногдох бүх ногдол ашгийг, 34 хувь ба түүнээс дээш бол 34 хувьд ногдох ногдол ашгийг хуваарилахаар тус тус зохицуулсан бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны талаар тусгагдсан зорилт, арга хэмжээтэй нийцтэй байдлаар санхүүжүүлэх замаар сангийн хөрөнгийг удирдана. Үндэсний баялгийн сангийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийг хүртэл хугацаанд Хуримтлалын санд нийт 459,000,104,366.00 төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлсэн. Хөгжлийн сангийн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарсан тохиолдолд гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байснаас нэмэгдэж орох төсвийн орлогын 50 хувиар эх үүсвэрийг бүрдүүлнэ. Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 12.1-т Баялгийн сангийн төсөв нь төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулсан. Энэ хүрээнд Үндэсний баялгийн сангийн төрөлжсөн сангийн нэг Хуримтлалын сангийн дансыг Монголбанканд нээж, удирдуулах ажлыг зохион байгуулж, үүний дагуу 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдөр хуримтлалын сангийн хөрөнгийн удирдлагын гэрээг Монголбанкт байгуулсан болно.	
--	--	-----------------------------	--	--	--	--

7		4.1.3. Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлнэ.	2020 - 2050			Засгийн газрын болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог хөгжүүлэх зорилтын хүрээнд Засгийн газрын 2024 оны 169 дугаар тогтоолоор батлагдсан "Засгийн газрын өрийн баталгааны дагуу байгуулах гэрээ, түүнд тавигдах шаардлага, авлага барагдуулах журам"-ыг баталсан бөгөөд энэхүү журмын 10 дугаар зүйлийн 10.4.4 дэх заалтад "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр эрсдэлийн үнэлгээг шинэчлэн хийх бөгөөд эрсдэлийн үнэлгээний үзүүлэлт буурсан, нөхцөл байдал өөрчлөгдсөн тохиолдолд дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах;" гэж тусгасан. Түүнчлэн Улсын Их Хурлын 2022 оны 26 дугаар тогтоолоор "Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичиг"-ийн 5 дугаар зорилтод "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргах Засгийн газрын өрийн баталгаанаас төсөвт үүсэж болзошгүй эрсдэлийг үнэлэх, эрсдэлээс сэргийлэх чиглэлээр өрийн удирдлагын чадавхыг бэхжүүлж, бүртгэл хөтлөх, тайлагнах механизмыг бүрдүүлэх;Засгийн газрын өрийн баталгаа гаргасан төслүүдийн эргэн төлөлт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж, болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах;" гэж тус тус тусгасан.	100%
8		4.1.4. Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг барагдуулж, хугацаанаас нь өмнө худалдан авах, дахин санхүүжүүлэх арга хэмжээг авна.	2020 - 2050			Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичгийн 1 дүгээр зорилт, Засгийн газрын 2021 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын гадаад үнэт цаас гаргах, арилжаалах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийн эдийн засаг, төсөвт үзүүлэх ачааллыг жигдлэх, өрийн үйлчилгээний зардлыг бууруулах зорилгоор 2022-2023 онд эргэн төлөгдөх “Гэрэгэ” бондын 16.3 сая ам.доллар, “Чингис” бондын 2.5 сая ам.доллар буюу нийт 18.8 сая ам долларын Засгийн газрын гадаад үнэт цаасыг зах зээл уналттай байгаа цаш үеийг ашиглан эргэн төлөгдөх үнээс хямд өртөгтэйгөөр нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан худалдан авах өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Дээрх нээлттэй зах зээл дээрээс буцаан худалдан авах өрийн зохицуулалтын үр дүнд Засгийн газрын өрийн үйлчилгээний	100%

					зардлаас нийт 1.4 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн хэмнэлтийг улсын төсөвт гаргасан. Түүнчлэн, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд болон Засгийн газрын гадаад үнэт цаасны хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалах, харилцааг сайжруулах ажлын хүрээнд тэдэнд Монгол Улсын нийгэм эдийн засаг, төсөв санхүүгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж, биет болон цахим уулзалтуудыг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. Түүнчлэн, 2023 онд Номад бондын төлбөрөөс 22 сая ам.долларыг хугацаанаас нь өмнө худалдан авч 0.5 сая ам.долларын хэмнэлт үүсгэсэн бол 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Номад бондын 12 сая ам.долларын үлдэгдэл болон Сенчири-1 бондын 76 сая ам.долларын үлдэгдлийг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авч улсын төсөвт 1.8 сая ам.долларын хэмнэлтийг үүсгээд байна.	
9		4.1.6. Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна.	2020 - 2050		Улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь нь 2020 онд 12.5 хувь, 2021 онд 8.8 хувь, 2022 онд 5.1 хувьтай тэнцэхээр батлагдсан. Засгийн газрын 2023-2025 оны стратегийн баримт бичиг хэрэгжих хугацаанд энэхүү үзүүлэлт буурч 2025 оноос эхлэн төсвийн алдагдал ДНБ-ний 2 хувиас хэтрэхгүй, эсхүл ашигтай байх төлөвлөгөөтэй байна. Засгийн газрын гадаад үнэт цаасны хувьд 2020 онд хугацаа тулаад байсан “Мазаалай” бонд болон “Чингис” бондын төлбөрийг “Номад” бондоор төлсөн бөгөөд хуваарьт хугацаанд “Мазаалай” үнэт цаасны 133 сая ам.долларын төлбөрийг төсвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан. Түүнчлэн, 2021 онд “Чингис” бонд болон “Гэрэгэ” бондын үндсэн төлбөрийг “Сенчири” бондоор өрийн зохицуулалтын арга хэмжээ авсан бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр үлдэгдэл төлбөр болох 137 сая ам.долларыг төлж барагдуулсан болно.Тус төсвийн алдагдлыг бууруулах бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл -3.6 хувьтай тэнцэх төлөвлөгөөтэй байсан бол гүйцэтгэлээр 1.1 хувь буюу 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Мөн онд Сенчири-2	100%

					болон Сенчири-3 бондуудыг олон улсын зах зээлд арилжаалж Гэрэгэ, Хуралдай бондуудын хүрээнд өрийн зохицуулалт хийсэн бөгөөд 2023 онд Гэрэгэ бондын үлдэгдэл төлбөр болох 90.8 сая ам.долларыг, 2024 онд Хуралдай бондын үлдэгдэл төлбөр болох 52.9 сая ам.долларыг тус тус төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулж, Засгийн газрын гадаад үнэт цаасны үлдэгдлийг бууруулаад байна.	
10		4.1.7. Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж, улмаар ашигтай болгож, хуримтлал үүсгэж, төсвийн тогтвортой байдлыг хангана.	2020 - 2050		Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т “нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2017 онд 10.4 хувиас, 2018 онд 9.5 хувиас, 2019 онд 6.9 хувиас, 2020 онд 12.5 хувиас, 2021 онд 8.8 хувиас, 2022 онд 5.1 хувиас, 2023 онд 3.6 хувиас, 2024 онд 2.8 хувиас тус тус хэтрүүлэхгүй, 2025 оны төсвийн жилээс эхлэн нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл нь тухайн төсвийн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр хувиас илүүгүй алдагдалтай, эсхүл ашигтай байна” гэж тусгасан. Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасны дагуу төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг үе шаттай бууруулж байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 2021 онд ДНБ-ий 6.7 хувь, 2022 онд 1.9 хувь байсан бол 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарч ДНБ-ий 1.3 хувьд хүрсэн. Хуульд заасны дагуу 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлыг ДНБ-ий 2.0 хувь байхаар төлөвлөн батлуулсан.	100%
11		4.1.8. Хөгжлийг дэмжих бодлого, төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах судалгааны институт	2020 - 2050		Шинэ сэргэлтийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, оролцогч байгууллага, салбарын үйл ажиллагааны уялдааг хангах, тэдгээрт мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Засгийн газрын 55 дугаар тогтоолоор "Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төв" улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулахаар шийдвэрлэсэн. Тус УТҮГ нь Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгаа, техник туслалцаа үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй институт юм. Одоогоор Дэд бүтцийн хөгжлийн бодлогын газар, Ногоон, бүтээмжтэй хөгжлийн бодлогын газар, Захиргааны удирдлагын хэлтэс гэсэн	100%

		байгуулж ажиллуулна.				бүтэцтэйгээр, 30 гаруй ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.Засгийн газраас баримталж буй хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлж, хүртээмжтэй өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэн, хөрөнгө оруулалтыг дэмжих ажлыг эрчимжүүлэхэд боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот хөдөө, ногоон хөгжил, төрийн бүтээмжийн чиглэлээр яам, агентлагуудтай хамтран ажиллаж төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Түүнчлэн, Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газар нь Алсын хараа 2050, Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжих "Бүсчилсэн хөгжил"-ийн нийт 5 бүсийн тэргүүлэх чиглэл болон хэрэгжүүлэх арга хэмжээг бүс тус бүрээр судалж, танилцуулга бэлдэж цаг тухай бүрд мэдээлж ажилласан.	
12		4.1.9. Эдийн засгийн мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2050			Цар тахлын хүндрэлээс шалтгаалж эдийн засгийн өсөлт саарсан 2020-2021 онуудад төсвийг тэлэх, мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээ хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд нийгмийн халамжийн зардлыг нэмэгдүүлэх, албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, иргэд аж ахуйн нэгжүүдийн хэрэглээний зардлыг төрөөс хариуцах зэрэг мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлсэн. Харин 2022 оноос эхлэн эдийн засгийн өсөлт хурдсаж байгаатай холбогдуулан инфляцын өсөлтийг сааруулах болон төсвийн тэнцлийг сайжруулах, экспортыг нэмэгдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх багц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нүүрсний экспорт сэргэж 2022 онд 31.8 сая ам.долларт хүрч өмнөх оноос 2 дахин өссөн бөгөөд нийт экспорт 12.5 тэрбум ам.долларт хүрсэн. Түүнчлэн, 2023 оны төсвийн бодлогоор эдийн засгийг тогтворжуулах, төсвийн сахилга батыг бүх шатанд хэрэгжүүлэхэд чиглэн, ашигт малтмал дагасан далд эдийн засгийг ил болгох, төрийн өмчит компаниудын засаглал, үр ашгийг сайжруулах замаар төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлсэн. Засгийн газраас нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүссэн бэрхшээлийг арилгаж, биржээр нээлттэй, ил тод арилжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулдаг болсноор нүүрсний экспортын хэмжээ 2023 онд 69.6 сая тоннд хүрч, эдийн засгийн өсөлт урьдчилсан	100%

					байдлаар 7.0 хувь, экспортын хэмжээ 15.2 тэрбум ам.долларт хүрлээ. Ингэснээр 2023 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 24.4 их наяд төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 785.9 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Ийнхүү эдийн засаг сэргэснээр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн зорилтод хүрэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд 2024 оны төсвийн бодлогыг чиглүүлнэ. Энэ хүрээнд “Шинэ сэргэлтийн бодлого”-ын тулгуур бүрэлдэхүүн болох “Хот, хөдөөгийн сэргэлт”-ийн зорилтод тусгасан хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж байна.	
13		4.1.10. Татварын шинэ хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогын бааз суурийг өргөжүүлнэ.	2020 - 2050		Бүсчилсэн хөгжлийг татварын бодлогоор дэмжих татварын багц хуулийг боловсруулан 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр УИХ-д өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулсан. Ингэснээр бүсийн хөгжлийн бодлогод нийцүүлэн 20 гаруй татварыг бүсээр ялгаатай тогтоох боломж бүрдсэн бөгөөд бүсийн хөгжлийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл арга хэмжээний НӨАТ-ыг төлөх хугацааг 4 жил хүртэл хугацаагаар сунгах, эсхүл уг татварыг 4 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэх эсэхийг тухайн бүсийн Засаг дарга нар санал болгож, Засгийн газар шийдвэрлэх боломжтой болсон. Мөн тус өдөр нийгмийн хариуцлагын хүрээнд хуульд заасан чиглэлээр хөрөнгө оруулалт хийсэн аж ахуйн нэгжид борлуулалтын орлогын 1 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээгээр татварын хөнгөлөлт үзүүлэх хуулийн төслийг боловсруулан УИХ-д өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулсан. Түүнчлэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр УИХ-д өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулсан.	100%
14		4.1.11. Тансаг зэрэглэлийн бараа, бүтээгдэхүүн	2020 - 2050		Дэлхийн улс орнуудын туршлагаас тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, автомашин болон хэрэглээний бараа бүтээгдэхүүнд тусгайлан тансаг хэрэглээний татвар ногдуулах, тус татварыг нийгмийн дээд давхаргад ногдуулж төсвийн	50%

		ий импортын татвар, зохицуулалтыг олон улсын гэрээ, хэлэлцээрт заасан хүрээнд үр ашигтай хэрэгжүүлнэ.				зарлага хэлбэрээр нийгмийн доод давхаргад зарцуулах, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах асуудлыг судалж байна.	
15		4.1.12. Инфляцыг зорилтот түвшинд хадгалж, эрсдэл даахуйц гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхийг дэмжсэн мөнгөний бодлого хэрэгжүүлнэ.	2020 - 2050			Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	Хамааралгүй
16		4.1.13. Төв банкны гадаад өрийг бууруулах зорилгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ардын банктай байгуулсан	2020 - 2050			Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	Хамааралгүй

		“СВОП” хэлцлийн хүрээнд үүссэн өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахг үйгээр шийдвэрлэнэ .					
17		4.1.14. Макро эдийн засгийн зорилттой нийцүүлж, төсөв, мөнгөний бодлогыг харилцан уялдаатайгаа р хэрэгжүүлнэ.	2020 - 2050			Цар тахлын болон геополитикийн хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримталсан. Цар тахлаас улбаатай эдийн засгийн идэвхжил удааширч 2020 оны эцэст инфляцын түвшин 2.3 хувьд хүрээд байсан бол БНХАУ дахь цар тахлын эсрэг хатуу хөл хорио, ОХУ-Украины геополитикийн хурцадмал байдлаас үүдэлтэйгээр нийлүүлэлтийн гаралтай инфляц идэвхжиж 2022 оны 6 сард сүүлийн 10 жилийн дээд түвшин болох 16.9 хувьд хүрч өссөн. Инфляцыг бууруулах, голлох бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эсрэг 2022 оны 4 дүгээр сард “Гол нэр төрлийн зарим, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийг батлан дотоодын хүнс, импортын голлох хүнс, газрын тосны бүтээгдэхүүний нөөцийг бүрдүүлж нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хөнгөлөлттэй зээл, гааль, онцгой албан татварын хөнгөлөлт, газрын тосны бүтээгдэхүүний хямдралтай үнийн гэрээ зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Түүнчлэн Төв банк бодлогын хүүг 2022 онд дараалан 5 удаа өсгөн 13 хувьд хүргэж инфляцыг бууруулах чиглэлд төсөв, мөнгөний бодлогын уялдааг ханган ажилласны үр дүнд инфляцын хурд саарч 2023 оны эцэст 7.9 хувь болж Төв банкны зорилтот хэмжээнд хүрсэн. Улмаар Засгийн газраас 2023 онд төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой	100%

					хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримталсан. Бодлогын хүрээнд нүүрсний олборлолт, тээвэрлэлт, хилээр нэвтрүүлэх үйл ажиллагаанд үүссэн бэрхшээлийг арилгаж, ашигт малтмалын бүтээгдэхүүнийг уул уурхайн биржээр нээлттэй, ил тод арилжиж, олон улсын зах зээлийн үнээр борлуулдаг болсны үр дүнд нүүрсний экспорт 69.6 сая тоннд хүрч, улмаар эдийн засгийн өсөлт урьдчилсан байдлаар 7.0 хувь, экспортын хэмжээ 15.2 тэрбум ам.долларт хүрсэн. Ингэснээр урьдчилсан гүйцэтгэлээр 2023 оны нэгдсэн төсвийн нийт орлого 24.3 их наяд төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл ашигтай гарлаа. Ийнхүү эдийн засаг сэргэснээр “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн зорилтод хүрэх “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд 2024 оны төсвийн бодлогыг чиглүүлж байна.	
18		4.1.15. Санхүүгийн системийн эмзэг байдлыг бууруулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.	2020 - 2050		Засгийн газрын 2017 оны 299 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг батлуулж, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, явцыг тухай бүр Засгийн газарт танилцуулж ажилласан. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аас 2020 онд баталсантай холбоотойгоор Засгийн газрын 2020 оны 314 дүгээр тогтоолоор “Санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх” хөтөлбөрийг хүчингүй болгосон. Үүний дараа Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас баталсан “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” 2021 оны 314 дүгээр тогтоолоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хүчингүй болгосон. Дээрх хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэхээр тодорхойлж төлөвлөсөн дунд хугацааны бодлого, зохицуулалтын арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлага тавигдаж байгаатай холбоотойгоор “Санхүүгийн салбарын бодлогын арга хэмжээний төлөвлөгөө /2023-2024/”-ний төслийг боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын Зөвлөлийн гишүүдийн 2023 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А-34/106/43/А/20 тоот хамтарсан тушаалаар батлуулж,	100%

					хэрэгжилтийг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ханган ажиллаж байна.	
19		4.1.20. Экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий салбаруудын бараа бүтээгдэхүүний судалгаа, маркетингийг дэмжинэ.	2020 - 2050		Санхүү, төсвийн судалгааны газар нь 2024 онд тогтмол Монгол улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүд болох нүүрс, зэсийн зах зээлийн талаар дэлгэрэнгүй судалгаа хийсэн. Олон улсын зах зээл дээрх эрэлт, нийлүүлэлтийн гаралтай үнийн хэлбэлзэл, геополитикийн нөхцөл байдал, дэлхийн түүхий эдийн хамгийн том хэрэглэгч болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар, нийт эрэлт зэргээс хамаарсан түүхий эдийн үнийн цаашдын хандлагыг судалж, мэдээлэл бэлтгэж олон нийтэд мэдээлсэн. Мөн нүүрсний экспортын биет хэмжээ, өдөр тутмын үнийн мэдээллийг цаг тухай бүрд мэдээлсэн. 2024 оны жилийн эцсийн байдлаар гаалийн хорио цээрийн хяналтад хамрагдсан экспортын барааны гаалийн мэдүүлгийн статистик мэдээнээс харахад нийт 1856 аж ахуйн нэгж, 205 иргэний 9900 мэдүүлгээр экспортлогдсон бараа нь /цэвэр жин 170,5 мян.тн, бохир жин 173,8 мян.тн, 864,2 мян.доллар/ 1205 автомашинаар, 91 чингэлгээр, 78 ТИР машинаар, 86 вагоноор, 985 онгоцоор тус тус тээвэрлэгдсэн байна. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих ажлын хүрээнд: Мал, амьтан, ургамлын тэдгээрийн гаралтай 18 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлохын тулд БНХАУ-аас тавьсан шаардлагын дагуу 248, 249 дүгээр журмаар заавал БНХАУ-ын цахим бүртгэлд аж ахуйн нэгжүүд үйлдвэрээ бүртгүүлэхээр тусгасны дагуу гаалийн байгууллагаас 2024.12.05-ны өдрийн байдлаар БНХАУ-д мах, махан бүтээгдэхүүн, экспортлох эрх хүсэж хүсэлт гаргасан 19 аж ахуй нэгжийн холбогдох баримт бичигт хяналт хийж, баталгаажуулан ХХААХҮЯ-д уламжилсан. Гаалийн arqs.gaali.mn цахим системээр 1524 аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан хүсэлт хүлээн авснаас мал, амьтны гаралтай бараанд экспортын гэрчилгээ 2336 аж ахуйн нэгжид 5508 ширхгийг олгож, БНХАУ-д 21515.8 тн адууны мах, 18585.6 тн	

					дулааны аргаар чанаж боловсруулсан үхэр, хонь, ямааны мах, Иран, Ирак, Азербайджан, Узбекистан, Вьетнам улсад, 23149.4 тн хонь, ямааны мах, БНХАУ-д адууны шир 128957ш, үхрийн хагас боловсруулсан шир 108725 ш, ямааны боловсруулсан арьс 39762540ш, хонины угаасан ноос 7476.5тн, ноолуур 4775.7тн-ыг тус тус экспортлоход гаалийн хорио цээрийн хяналтыг хийсэн байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар Гаалийн ерөнхий газар болон харьяа газар, хороодоос ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд нийт 1648 ширхэг экспортын гэрчилгээ олгосноос ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 533 ширхэг, БНХАУ-д хивэг экспортлох гэрчилгээ 136 ширхэг, БНХАУ-д буудайн гурил экспортлох гэрчилгээ 82 ширхгийг тус тус олгоод байна. Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 703 аж ахуйн нэгж, 106 иргэний бараа экспортолдсоноос мэдүүлгээр 1332, ангилалтын тоо хэмжээгээр 68,5 мян.тн, 20 мэдүүлгээр 270304 литр, 22 мэдүүлгээр 57000 ширхэг бараа экспортлогдсон.	
20		4.1.21. Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид	2020 - 2050		Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	Хамааралгүй

		тогтвортой хадгална.					
21		4.1.22. Хадгаламж, хуримтлалыг нэмэгдүүлэх дадлыг бий болгоно.				Монголбанкны хуулиар олгогдсон үндсэн чиг үүргийн арга хэмжээ тул Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасуулах саналтай байна.	Хамааралгүй
22		4.1.23. Хуримтлалын эх үүсвэрийг нэмэгдүүлж, зээлийн хүүг бууруулах замаар үндэсний үйлдвэрлэгчдийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.				Монголбанкны хуулиар олгогдсон үндсэн чиг үүргийн арга хэмжээ тул Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасуулах саналтай байна.	Хамааралгүй
23		4.1.24. Макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хадгалж, ажилгүйдлийг нам түвшинд тогтвортой хадгална.	2020 - 2050			Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул Сангийн яамны хариуцах арга хэмжээнээс хасах шаардлагатай.	Хамааралгүй
24		4.1.25. Зээлийн хүүг хөгжингүй орнуудын	2020 - 2050			Монголбанкны хуулиар олгогдсон үндсэн чиг үүргийн арга хэмжээ тул Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасуулах саналтай байна.	Хамааралгүй

		түвшинд хүргэж, тогтвортой хадгална.					
25	4.4. Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.	4.4.2. Бараа, үйлчилгээг худалдах, тээвэрлэх, хянах, хөрөнгө оруулах, зах зээлд нэвтрэх нөхцөлүүдийг ил тод болгох, бүртгэл ба мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, цаасгүй технологи нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан удирдлага ба хяналтыг бий болгоно.	2020 - 2050			Хяналт, бүрдүүлэлтийн чиглэлээр: ГЕГ, ТЕГ болон СМТТ УТҮГ хамтран “Гааль, татварын автомат бүрдүүлэлт”-ийн системд Гэрээ бүртгэлийн системийг нэвтрүүлж, гадаад болон дотоод худалдааны гэрээ, боловсруулах, баяжуулах гэрээ зэрэг ашигт малтмалын бүх төрлийн гэрээг бүртгэх мөн тус системд бүртгэгдсэн дотоод гэрээг цахим төлбөрийн баримтын системтэй холбож, төлбөрийн баримтыг цахимаар үйлдэх боломжтой болгосон. Гэрээ бүртгэлийн нэгдсэн системийн бодит орчинд 2024.01.01-11.30-ны өдрийн байдлаар 476 ААН-ийн ашигт малтмалын гадаад худалдааны 4872 үндсэн гэрээ, 194 ААН-ийн 2897 нэмэлт буюу нийт 7769 гэрээг цахимаар бүртгэсэн байна. Гаалийн байгууллагын CAIS системд 2024.01.01-11.30-ны өдрийн байдлаар гэрээ бүртгэлийн нэгдсэн системээс үндсэн гэрээг үндэслэн ашигт малтмалын экспортын 1121604 гаалийн бүрдүүлэлт хийж, 13542 гаалийн лабораторийн дүгнэлт, нэмэлт гэрээг үндэслэн ашигт малтмалын экспортын 111807 гаалийн бүрдүүлэлт хийж, 1527 гаалийн лабораторийн дүгнэлт гаргасан байна. Мөн 2024.11.30-ны өдрийн байдлаар Гэрээ бүртгэлийн нэгдсэн системд нийт 5995 тээврийн гэрээ бүртгэгдсэн байна. Гаалийн хорио цээрийн чиглэлээр: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн "Интерактив" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах” төслийн хүрээнд гаалийн хорио цээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг цахимжуулах 2024.02.27-ны өдрийн ГЕГ-ын даргын А/115 тушаалаар ажлын хэсгийг байгуулж, 16 модулийн хүрээнд төлөвлөгөө гарган Хорио цээрийн эрсдэлийг, гаалийн эрсдэлийн удирдлагын модультай уялдуулах зорилгоор	100%

					эрсдэлийн нэгдсэн журамд дурдсан эрсдэл тооцох өгөгдлүүдийг цахимжуулах, төрийн байгууллагуудтай өгөгдөл солилцох, лабораторийн модулийн шаардлагын тодорхойлолт, гар утасны апплейкшны загвар, хорио цээрийн модулийн цацраг, шарил, зорчигч, тээвэр, халдваргүйжүүлэлтийн дэд модульд засвар, сайжруулалт, хорио цээрийн хяналтын явцад буцаах мэдэгдлийн модулийг, хяналтын чиглэл бүрийн зааврыг тус тус боловсруулж, биелэлт 80 хувьтай байна. Уг төсөл 2025.04.01-ний өдрийг хүртэл ажиллана. Мэдээллийн технологийн чиглэлээр: Гэрээ бүртгэлийн системд экспортлогч ААН тээвэрлэгч аж ахуй нэгжтэй байгуулсан тээврийн гэрээг бүртгэдэг болгож, 2024.02.01-ны өдрөөс туршилтаар нэвтрүүлсэн. Гэрээ бүртгэлийн нэгдсэн системд бүртгэгдсэн тээврийн гэрээг экспортын гаалийн бүрдүүлэлт хийх үед экспортлогч ААН-ын регистрийн дугаар, гадаад худалдааны гэрээ, тээврийн хэрэгслийн дугаар гэсэн утгуудаар хайлт хийж экспортын гаалийн мэдүүлэгт цахимаар заавал татах хөгжүүлэлтийг ceps.gaali.mn болон gaali.mn дээр хийж нэвтрүүлсэн. КАИС системд ББГУБ болон ГУАБ–ын эрх дээр тээврийн гэрээг харуулах болон гаалийн цахим үйлчилгээний гааль.мн системд гэрээний дугаараар тухайн гэрээний мэдээллийг харах хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн. Мэдүүлэг гааль зөвшөөрөв төлөвт ороход бараа бүртгэлийн нэгдсэн систем рүү гаалийн мэдүүлгийн мэдээллийг, тээврийн гэрээний мэдээлэлтэй хамт илгээдэг болгож хөгжүүлэлт хийж нэвтрүүлсэн.	
Тав. ЗАСАГЛАЛ						
26	5.2. Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион	5.2.12. Төв банкны мөнгөний бодлого нь Монгол	2020 - 2050		Монголбанк /Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 болон 11 дүгээр зүйл./ Сангийн яамны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээнээс хасах шаардлагатай.	Хамааралгүй

	байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна.	Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх улс төр, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.					
27		5.2.22. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг нэгтгэн хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлнэ.	2020 - 2050			Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэх, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд шилжүүлэх чиглэлээр анхаарч, Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан ангиллын дагуу жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нарт зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд: 1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчинд 10.0 сая хүртэл төгрөг, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэн болон гадаад улсад хөдөлмөр эрхэлж байгаад буцаж ирсэн иргэнд 25.0 сая хүртэл төгрөг, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид 50.0 сая хүртэл төгрөгийн жижиг зээлийг олгох. 2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 300.0 сая хүртэл төгрөг, жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 1.0 тэрбум хүртэл төгрөг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид 2.5 тэрбум хүртэл төгрөгийн зээлийг олгохоор зохицуулсан. Энэхүү хүрээнд 2024 оны 10 дугаар сарын байдлаар Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийт 15.7 тэрбум төгрөгийн зээл, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нийт 20.7 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгоод байна. Олон нийтэд нээлттэй, олон нийтийн хяналтын тогтолцоог сайжруулах хүрээнд Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24, 25 дугаар зүйл, Шилэн дансны тухай хуулийн 3, 6 дугаар зүйл болон эдгээр хуулиудад нийцүүлэн боловсруулсан тусгай сангуудын хөрөнгийг бүрдүүлэх, хөрөнгийг зарцуулах журмуудад тус тус заасны дагуу тусгай сангуудын хөрөнгийн зарцуулалт, зээл олголтын мэдээллийг сар бүр Шилэн дансанд олон нийтэд нээлттэй байдлаар тогтмол оруулж байна. Түүнчлэн	100%

						дээрх зохицуулалтын дагуу тусгай сангуудаас санхүүжилт, зээл олгох үйл явц болон үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор тусгай сангуудын сонгон шалгаруулалтын хороодын бүрэлдэхүүнд заавал хараат бус, олон нийтийн төлөөллийг оролцуулж ажиллах шаардлагыг ханган хэрэгжүүлж байна.	
Найм. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ							
28	8.1. Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.	8.1.8. Хавирга, Гашуунсухайт, Шивээ хүрэн, Булган, Боршоо, Арц суурь, Бага Илэнхи зэрэг хилийн боомтуудын нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ.	2020 - 2050		1. Хавирга, Шивээхүрэн, Боршоо, Арц суурь, Бага Илэнхи зэрэг хилийн боомтууд	2024 онд “Баян-Уул сумаас Ульхан боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 50 км /Дорнод, Баян-Уул сум/” төсөлд 20,892.6 сая төгрөг батлагдаж, 12-р сарын 10-ны өдрийн байдлаар 16,156.7 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2025 оны төсөлд тус төслийн хэрэгжих хугацаа 2022-2026 он, төсөвт өртөг 84,892.6 сая төгрөг, санхүүжигдэх дүн 29,000.0 сая төгрөгөөр батлагдсан. 2024 онд “Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/” төсөлд 27,500.0 сая төгрөг батлагдаж, 12-р сарын 10-ны өдрийн байдлаар 24,499.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2025 оны төсөлд тухайн төслийн хэрэгжих хугацаа 2022-2027 он, төсөвт өртөг 185,514.9 сая төгрөг, санхүүжигдэх дүн 48,532.9 сая төгрөгөөр батлагдсан. 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд “Хилийн боомтуудын барилга байгууламжийн их засвар /Боомтуудад/” төсөлд 2710,9 сая төгрөг, “Боомтын сэргэлтийн Үндэсний хороо болон хилийн боомтуудын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/” төсөлд 5359,4 сая төгрөг батлагдсан. “Нөмрөг-Улаангом чиглэлийн А18 дугаартай авто замаас Арцсуурь хилийн боомт хүртэлх хатуу хучилттай авто зам, 159.5 км /Баруун бүс/” төслийн хэрэгжих хугацаа 2025-2027 он, төсөвт өртөг 199,422.0 сая төгрөгөөр, 2025 онд санхүүжигдэх дүн 39,884.4 сая төгрөгөөр тус тус батлагдсан. Боршоо боомтод зорчигч тээврийн 21 барилга байгууламж, дэд бүтэц, ногоон байгууламж баригдсан. Түүнчлэн шуурхай удирдлагын төвтэй холбогдсон орчин үеийн теле хяналтын систем, өндөр хүчин чадлын рентген, тоног төхөөрөмжүүд суурилагдсан.	100%

						Боомтын шинэчлэлээр нийт талбай 3.5 дахин, өдөрт нэвтрэх зорчигчийн тоо 4,8 дахин, ачааны автомашины тоо 3 дахин, суудлын тээврийн хэрэгслийн тоо 6.7 дахин нэмэгдэж зорчигч, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэн, ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэж Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засгийн хөгжилд томоохон нөлөө үзүүлнэ. CW8: Боршоо хилийн боомтын авто зам, гадна инженерийн шугам сүлжээний угсралтын ажил - Сайн констракшн ХХК-тай 2020 оны 7 сарын 20-нд гэрээ байгуулсан. Гэрээний дүн: \$3,445,264.10 Хэрэгжилт – 100%. CW9: Боршоо хилийн боомтын барилга байгууламжийн угсралтын ажил - "И Си Си" ХХК-тай 2020 оны 7 сарын 20-нд гэрээ байгуулсан. Гэрээний дүн: \$ 3,666,034.91	
				36'715.74	Шилжих 2. Гашуунсухайт хилийн боомтод БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр болон Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан барилга байгууламж, авто зам талбай, инженерийн шугам сүлжээний ажилд хяналт тавих, холбогдох асуудлыг шийдвэрлүүлэн ажиллах, улсын	Гашуунсухайт хилийн боомтод БНХАУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр 37 нэрийн, Улсын төсвийн хөрөнгөөр 6 нэрийн барилга байгууламж, авто зам талбай, инженерийн шугам сүлжээн ажилд хяналтыг тавьж, холбогдох асуудлыг тухай бүр нь шийдвэрлүүлэн ажилласан. Улсын комиссыг үе шаттайгаар зохион байгуулан ашиглалтад өгсөн. Үр дүн 100%.	

					комисст өгсөн байна.		
				1'767.33	Шинэ 3. Улсын төсвийн хөрөнгөөр дараах барилгуудын тендер зарлах, ажлыг хянаж гүйцэтгэл баталгаажуулах. - Гашуунсухайт боомтын Хайрхан багийн авто зам, гадна гэрэлтүүлэг, гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил. Үр дүн 58%-д хүрэх. - Өмнөговь аймаг, Ханбогд сум Хайрхан багийн нутаг дэвсгэрт баригдах Ажилчдын орон сууцны ЕТ№34 (Б, В, Г1, Г2, Г3 блок) барилга угсралтын ажил Үр дүн 12%-д хүрэх. - Гашуунсухайт боомтын ахуйн	Тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан. БУА-ыг хянаж үе шатны ажлуудын гүйцэтгэлийг баталгаажуулан санхүүжүүлж байна. Үүнд: - Гашуунсухайт боомтын Хайрхан багийн авто зам, гадна гэрэлтүүлэг, гадна тохижилт, ногоон байгууламжийн ажил. Үр дүн 58.7%-д хүрсэн. - Өмнөговь аймаг, Ханбогд сум Хайрхан багийн нутаг дэвсгэрт баригдах Ажилчдын орон сууцны ЕТ№34 (Б, В, Г1, Г2, Г3 блок) барилга угсралтын ажил Үр дүн 12%-д хүрсэн. - Гашуунсухайт боомтын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх тоног төхөөрөмж худалдан авах угсарч суурилуулах ажил хийгдэж байна. Гүйцэтгэл 20%-тай.	

					бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх тоног төхөөрөмж худалдан авах угсарч суурилуулах Үр дүн 100%-д хүрэх.	
				399.61	4. Булган хилийн боомтын ТЭЗҮ, Байгаль орчны үнэлгээ, зураг төсөл боловсруулах ажилд хяналт тавих, магадлалаар батлагдсан зураг төслийг хүлээн авна.	1. Боомтын Техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ тайлан //2024.03.24, №372/2024/ магадлалаар хянагдаж баталгаажсан ба хүлээн авсан. 2. Боомтын нарийвчилсан зураг төсөл магадлалаар хянагдсан, төсөвт өртөгт магадлал хийгдэж байна. 3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ /БОННУ/-ний тайланг БОУАӨЯ-нд илгээсэн, хурлаар хэлэлцэгдсэн /2024.10.29/. Ашиглагч байгууллагуудаас боомтын ажилчдын суурьшлын бүсэд өөрчлөлт оруулсан тул /2024.10.29/ гэрээ сунгагдсан. Нийт гүйцэтгэл 96 хувьтай байна.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2025-2030-2050			Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээллийн эх үүсвэр	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж	Хэрэгжилт	Үнэлгээ
				2025	2030	2050						

31	Дотоодын нийт бүтээгдэхүүн	тэрбум ам. доллар	13.1	23.9	47.6	209.0	Оны үнээрх ДНБ	Үндэсний статистикийн хороо, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Монгол Улсын нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 56.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд уул уурхай, тээвэр, худалдаа, үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлт голлох нөлөө үзүүлсэн байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд Эдийн засаг, хөгжлийн яамны тооцооллоор 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 79.2 их наяд төгрөгт хүрэхээр тооцсон. Ам.долларын дундаж ханшийг 2024 онд 3,400 гэж үзвэл ам.доллараар илэрхийлсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 23.3 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.	100%
33	Инфляц	хувь	8.1	6	6	2	Мөнгөний оновчтой бодлогыг инфляцын түвшнээр хэмжинэ.	Үндэсний статистикийн хороо, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Салбарын тайлан	Жилд нэг удаа	2024 оны 10 дугаар сарын байдлаар инфляцын түвшин 7 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2 нэгж хувиар буурсан бол өмнөх оны эцсээс 5.8 хувь, өмнөх сараас 0.5 хувиар өссөн байна. Ингэснээр 2024 оны эхний 10 сард инфляцын түвшин Монголбанкны зорилтот түвшинд хадгалагдаж байгаа бөгөөд эхний 10 сарын дундаж нь 6.5 хувьтай байна. 2024 оны	100%

											хүлээгдэж буй гүйцэтгэлээр жилийн дундаж инфляц 6.5 хувьд хүрэхээр ЭЗХЯ-аас тооцоолж байна.	
ЗУРГАА.НОГООН ХӨГЖИЛ												
61	Засгийн газрын ногоон худалдан авалтын эзлэх хувь	хувь	-	10	20	50		Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Худалдан авах ажиллагааны газар	Салбарын тайлан	Жилд нэг удаа	Техникийн тодорхойлолтыг хүрээлэн байгаа орчинд ээлтэй хэлбэрээр боловсруулах аргачлал, зааврыг боловсруулж, Сангийн сайд болон Байгаль, орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлуулах ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 03/1960 тоот албан бичгээр тухайн аргачлал зааврыг боловсруулж, батлуулах ажлын хэсэгт ажиллах албан хаагчийн нэрийг ирүүлэхийг хүссэн байх бөгөөд тус яам 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 03/3446 тоот албан бичгээр хамтран ажиллах албан хаагч нарын нэрийг хүргүүлж, хамтран ажиллаж байна.	100%